Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн систем

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө

ГАРЧИГ

1 ТАНИЛЦУУЛГА 4

1.1 Баримт бичгийн дугаар 4

1.2 Зорилго 4

1.3 Үйлчлэх цар хүрээ 5

1.4 Хэрэгжүүлж эхлэх хугацаа 5

1.5 Хариуцагч 5

2 ХАМРАХ ХҮРЭЭ 6

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ 6

2.2 Менежментийн бусад төлөвлөгөөтэй давхцах тухайд 6

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА 6

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг ба хариуцлага 6

3.2 Голлон хариуцах талууд 7

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД 8

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж 8

4.2 Баримталбал зохих Монгол улсын стандартууд 8

4.3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлагууд 9

4.4 Баримталбал зохих олон улсын стандарт, удирдамжууд 9

4.5 Баримталбал зохих Сентеррагийн стандартууд 10

5. НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ 10

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ 17

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянан нягталж, шинэчлэх 17

7 ХЯНАЛТ 17

7.1 Хяналт хийхэд тавигдах шаардлагуудын тойм 17

7.2 Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд 17

7.3 Хяналтын үндсэн үйл ажиллагаа 18

8 СУРГАЛТ 18

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ 19

9.1 Дотоод аудит 19

9.2 Гадаад аудит 19

9.3 Бүртгэл, тэмдэглэл хөтлөх 19

Хавсралт 1: Олон нийтийн замын хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийн талаарх хураангуй 20

Бэлчээр ашиглалтад үзүүлэх авто замын нөлөөлөл 20

Иргэдийн амьжиргаанд үзүүлэх авто замын нөлөөлөл 20

Замын хөдөлгөөний үеэр осол зөрчил гарах 21

Биет бус соёлын өв болон олон нийтийн аюулгүй байдал 21

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Хариуцагч ба хариуцлага....6
Хүснэгт 2 Менежментийн үндсэн хяналтууд....11
Хүснэгт 3 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт ба хяналтын арга хэмжээ – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент....17
Хүснэгт 4 Хяналтын үндсэн арга хэмжээ....18

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичиг нь Гацууртын алтны уурхайн төслийн (цаашид 'Гацуурт' эсвэл 'Төсөл' гэх) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө (цаашид 'ЗХАБМТ' эсвэл 'Менежментийн төлөвлөгөө' гэх) юм. Ажлын талбайд явган зорчигчид болон жолооч нарын мөрдлөг болгох замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн тусгайлсан арга хэмжээ түүнчлэн талбайгаас бусад газар баримталбал зохих замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн арга хэмжээнүүдийг эл ЗХАБМТ-нд нэгтгэн тусгав.

1.2 Зорилго

Сентерра Гоулд Инк (Сентерра) болон Монгол улс дахь зуун хувийн эзэмшлийн охин компани нь болох Бороо Гоулд Компанийн (БГК) зүгээс Гацууртын төсөлд зориулж энэхүү ЗХАБМТ-г боловсруулав. Энэ нь БГК-ийн зүгээс Гацууртын төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийг хэрэгжүүлэхээр боловсруулсан цуврал менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг юм. ЗХАБМТ-нд Төсөлтэй холбоотой замын хөдөлгөөнөөс улбаалан үүсч болзошгүй дотоод, гадаад үндсэн эрсдэлүүдийг багасгахын тулд уурхайн барилга, ашиглалт, хаалтын гэсэн гурван үе шат тус бүрт Төсөлд хамааралтай замын хөдөлгөөний менежмент хийх механизмыг тусгав. ЗХАБМТ-г нийтийн хэрэглээнд мөн ашиглагдах Гацууртаас Бороо хүртэлх уурхайн тээврийн замын хөдөлгөөнд ерөнхийд нь зориулан боловсруулав. Болзошгүй нөлөөллүүдээс юуны өмнө зайлсхийх, нөлөөллийг бууруулах буюу менежмент хийхэд хэрэгжүүлбэл зохих нийтлэг арга хэмжээнүүдийг ЗХАБМТ-нд онцлон тусгасан болно. Менежментийн төлөвлөгөөний ерөнхий зорилго нь:

- Төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, менежментийн арга ажиллагааг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх чиг үүрэгтэй талуудыг тодорхойлох;
- Төлөвлөгөөг хариуцагчдын үүрэг, хариуцлагыг нь тодорхойлох;
- Тус төлөвлөгөөнд баримталбал зохих 'Төслийн стандартууд'-ыг тоймлон тусгах;
- Төслийн үүрэг, үйл ажиллагааны журам болон удирдамжуудаас эл төлөвлөгөөнд хамааралтайг нь тодорхойлох;
- Хяналт тавих, тайлагнах журам, тэр дундаа гүйцэтгэлийн үндсэн шалгууруудыг тодорхойлох;
- Холбогдох сургалтын шаардлагуудыг тодорхойлох;
- Дагалдах материал, мэдээллийн лавлагааг зааж өгөхөд тус тус оршино.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь замын хөдөлгөөний менежментийн арга хэмжээний ерөнхий зарчмыг тодорхойлох бөгөөд төлөвлөгөөг уурхайн барилгын үе шат эхлэхээс өмнө нарийвчлан боловсруулна. Энэхүү ЗХАБМТ-гөөр:

- Замын хөдөлгөөнд оролцогч бүрийг аюулгүй орчноор хангах;
- Явган зорчигчид болон ажиллагсдыг автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсч болзошгүй аюул, эрсдэлээс хамгаалах;
- Машины зогсоолын талбайг хүрэлцээтэй байлгах зорилгуудыг тусгайлан тавьж буй.

Энэхүү ЗХАБМТ нь нийтийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн талаар дараах зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн зорилтууд нь ажиллагсад, ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчид, зочид зэрэг компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор замын хөдөлгөөнд оролцогсод, түүнчлэн орон нутгийнхан болон авто замаар зорчигч бусад оролцогсдын хувьд ойлгомжтой байх;
- Нийтийн хэрэглээний замаар зорчигчид болон холбогдох эрх бүхий байгууллагуудтай үр дүнтэй харилцаж ажиллахын тулд замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн зорилтуудыг мэдээлэн таниулахад зохих хүчин чармайлт гаргах;
- Замын хөдөлгөөнтэй холбоотойгоор учирч болзошгүй аюул, эрсдэлээс боломжтой тохиолдол бүрт зайлсхийх, эрсдэлийг аль болох бууруулах;

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

- Уурхайн машин, тээврийн хэрэгсэл уурхайн талбайд болон түүний орчинд, түүнчлэн Гацууртын тээврийн замын хөдөлгөөнд оролцох үед осол зөрчил гарах эрсдэлээс боломжтой тохиолдол бүрт зайлсхийх, эрсдэлийг аль болох багасгах;
- Уурхайн барилга, ашиглалт, хаалтын үе шатны үйл ажиллагаатай холбоотой тээврийн хэрэгслийн ашиглалт нь бохирдол (агаар, ус, тохь тух алдагдуулах) болон орон нутгийн тээврийн замуудад эвдрэл гэмтэл үүсгэхээргүй байх.

БГК нь Төслийн бүтээн байгуулалтын туршид эрх ашиг нь хөндөгдөх талуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг зорих бөгөөд энэ ЗХАБМТ шинэ мэдээлэл бий болох бүрт шинэчлэгдэж байх болно. Энэхүү баримт бичигт оруулсан аливаа өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн өмнө дотооддоо ярилцаж хэлэлцэн тохирно. Аливаа өөрчлөлт олон нийтийн замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөл үзүүлж болзошгүй тохиолдолд орон нутгийнхан болон эрх бүхий холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зохих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

1.3 Үйлчлэх цар хүрээ

Менежментийн төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь Гацууртын уурхайн бүхий үйл ажиллагаа, нийт ажиллагсад, ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчдэд хамаарна. Тус төлөвлөгөө нь БГК-ийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн системд (ЭМААБОМС) үндэслэсэн болно. ЭМААБОМС-д өөрчлөлт орвол энэ Менежментийн төлөвлөгөө мөн өөрчлөгдөж болно.

1.4 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Менежментийн төлөвлөгөө нь Гацууртын уурхайн барилгын үе шатнаас эхлэн хэрэгжинэ.

1.5 Хариуцагч

Гацууртын уурхайн ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал нь энэ менежментийн төлөвлөгөөг шууд хариуцагч байна.

Менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт хийх хүсэлтийг төлөвлөгөө хариуцагчид гаргах бөгөөд аливаа өөрчлөлт нь Компанийн өөрчлөлтийн менежментийн баримт бичигт заагдсан хянах болон батлах процессуудаар дамжин шийдвэрлэгдэнэ.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

Менежментийн төлөвлөгөө нь Гацууртын уурхайн үйл ажиллагааг нийтэд нь хамрах бөгөөд гэрээт гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчдэд мөн хамаарна. Уурхайн барилга, ашиглалт, хаалтын бүхий л үе шатны замын хөдөлгөөнд тус төлөвлөгөөг мөрдөх ба Гацууртаас Бороо руу гэрээгээр хүдэр тээвэрлэлт, компанийн болон гэрээт ажиллагсдын Гацууртын уурхай дахь болон Гацуурт Бороогийн хоорондын замын хөдөлгөөнд энэ төлөвлөгөө мөн мөрдөгдөнө.

2.2 Менежментийн бусад төлөвлөгөөтэй давхцах тухайд

Энэ ЗХАБМТ нь ЭМААБО-ны менежментийн системд тодорхойлогдож, Гацууртын төсөлд зориулан боловсруулагдсан багц менежментийн төлөвлөгөөнүүдийн нэг юм. Бусад менежментийн төлөвлөгөөнүүдэд орж давхацсан арга хэмжээнүүдийг энд давтан оруулаагүй болно (холбогдох бусад төлөвлөгөөтэй хамаатай хэсгүүдийг тэмдэглэн үлдээв).

- Гомдол барагдуулах журмыг агуулсан Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө;
- Агаарын бохирдлын менежментийн төлөвлөгөө (тоосжилтын нөлөөллийн менежментийн хувьд);
- Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө;
- Гадаргын усны менежментийн төлөвлөгөө;
- Онцгой байдлын менежментийн төлөвлөгөө;
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө;
- Уурхайн хаалтын төлөвлөгөө;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл мэндийн менежментийн төлөвлөгөө;
- Орон нутгийнхны хөдөлмөр эрхлэлт, Сургалтын менежментийн төлөвлөгөө.

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг ба хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх үүрэгтнүүд ба хариуцлагыг энэ хэсэгт тоймлон үзүүлэв.

Хүснэгт 1 Хариуцагч ба хариуцлага

Хариуцагч	Хариуцлага
Гацууртын Захирал	Төсөл нь энэхүү Төлөвлөгөөнд заасан бусад шаардлагууд болон Төслийн стандартуудад нийцэж байх явдлыг хангах. Төлөвлөгөө болон түүний хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц хөрөнгийг батлах.
Гацууртын Гадаад харилцаа, Тогтвортой байдлын асуудал эрхэлсэн захирал	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах. Төлөвлөгөөг боловсруулах, хянах, шинэчлэх асуудлууд.
Уурхай, Аюулгүй ажиллагаа, Аюулгүй байдал болон Тогтвортой байдлын асуудал хариуцсан менежерүүд	Энэ менежментийн төлөвлөгөөнд хамаарах сургалтын арга хэмжээг хэрэгжүүлэх. Зөвшөөрөгдсөн болон хязгаарлалдсан замаар зорчих хөдөлгөөнийг мөрдүүлэх. Аливаа замд зориулсан замын хөдөлгөөний хяналтын төлөвлөгөө (ЗХХТ) боловсруулах, батлах эрх, зөвшөөрөл олгох. Эрх бүхий байгууллагаар төлөвлөгөө батлуулах шаардлагатай үед Сентерраг төлөөлөх.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

Хариуцагч	Хариуцлага
	Төрийн эрх бүхий байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, гэрээт ажиллагсад, олон нийтийн бүлгүүд болон нийт иргэдтэй эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн асуудлаар ярилцлага, хэлэлцүүлэгт Сентерраг төлөөлөх. Төслийн замын хөдөлгөөнтэй холбоотойгоор үүсэж болзошгүй зөрчлийг бууруулахад орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй харилцаа холбоотой байх, зөвшилцөхөд Сентерраг төлөөлөх. ЗХАБМТ-ний хэрэгжилтэд үнэлгээ хийх. Энэ менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах аудитийг тогтмол хугацаанд хийх.
Хүний нөөцийн асуудал эрхэлсэн Захирал	Шаардлагатай сахилгын арга хэмжээг холбогдох хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсаны дагуу авах.
Олон нийтийн харилцаа хариуцсан Ахлах ажилтан	Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд, олон нийт болон бусад оролцогч талуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах замаар энэ төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх
Гэрээт гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчид	Өөрсдийн хяналтад байгаа бүхий л өмч хөрөнгө Гацууртын бодлого, журмуудад нийцэж байх явдлыг хангах. Хууль, журмын шаардлагын дагуу нотломж гэрчилгээ, тусгай зөвшөөрлийнхөө хуулбарыг өгөх. Байгаль орчин, нийгмийн менежментийн талаарх Гацууртын шаардлагуудыг биелүүлэх. Байгаль орчин, нийгэмд учирсан болон учирч болзошгүй бүхий л нөлөөллийн талаар холбогдох ахлагч ажилтан эсвэл удирдах байгууллагад мэдээлэх.
Ажиллагсад, Гэрээт гүйцэтгэгчид болон зочид	Өөрсдийн үйл ажиллагаанаас нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг аль болох бууруулах. Энэ менежментийн төлөвлөгөө болон Гацууртын холбогдох бусад байгаль орчны бодлого, журмуудад заагдсан үүргээ биелүүлэх. Гарсан зам тээврийн осол зөрчил болон байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар холбогдох ахлагч ажилтан эсвэл удирдах байгууллагад мэдээлэх.

3.2 Голлон хариуцах талууд

Энэхүү менежментийн төлөвлөгөөний холбогдох хэсгүүдийн хэрэгжилтийг дараах албан тушаалтнууд голлон хариуцна:

- Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирал бөгөөд Ерөнхийлөгч – Аюулгүй байдлын менежмент, талбайгаас гадуурх үйл ажиллагааны аюулгүй байдлын талаар;
- Хүний нөөцийн асуудал эрхэлсэн захирал – Ажиллах хүчин болон гэрээт гүйцэтгэгчдийн менежменттэй холбоотой хэсгийн талаар;
- Уурхайн олборлолт, Аюулгүй ажиллагаа, Тогтвортой байдлын асуудал хариуцсан менежерүүд – ЗХАБМТ-г хамтран хэрэгжүүлэх асуудлаар;
- Олон нийтийн харилцаа эрхэлсэн ажилтнууд –Зам ашиглагчдын аюулгүй байдлыг дээшлүүлэхэд олон нийтийг татан оролцуулах, мэдээлэл сурталчилгаагаар хангах асуудлаар.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж

Замын хөдөлгөөнтэй холбоотой Монгол улсын гол хууль тогтоомж, дүрэм, журмуудыг дор дурдав. Үүнд:

- Монгол улсын Авто замын тухай хууль;
- Монгол улсын авто замын зураг төслийн стандартууд;
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012.5.30-ны өдрийн 159 тоот тушаалаар батлагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай авто зам барих, ашиглах, засвар үйлчилгээ, арчлалтын түр журам";
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 201 дүгээр тушаалын хавсралтаар

батлагдсан Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм;

- Монгол улсын Засгийн газрын 2004 оны 74 тоот тогтоолоор батлагдсан Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015.7.08);
- Авто замын тухай хууль (1998.1.2);
- Автотээврийн тухай хууль (1999.6.4);
- Жолоочийн даатгалын тухай хууль (2011.10.6);
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль (1992.12.1);
- Эрүүгийн хууль: 24 дүгээр бүлэг. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (2002.1.3);
- Иргэний хууль: 35 дугаар бүлэг. Тээвэрлэлт (2002.1.10);
- Цагдаагийн албаны тухай хууль: 12 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх заалтууд (1993.12.2);
- Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай хууль (1997.9.9);
- Замын дохио, тэмдгийн тухай Венийн конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай хууль (1997.9.9);
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Хууль зүйн сайд нарын 2002.10.13-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам;
- Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам;
- Зам, тээврийн сайдын 2012.10.29-ний өдрийн 59 тоот тушаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам;
- Замын хөдөлгөөнд хяналт тавих журмууд.

4.2 Баримталбал зохих Монгол улсын стандартууд

Монгол улсын холбогдох гол журам болон стандартууд:

- Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах журам;
- Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам;
- Тээврийн хэрэгслийг албадан зогсоох заавар;
- Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам;
- Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам;
- Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам;
- Аюултай ачаа тээвэрлэх журам;
- Бага оврын автобусаар зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх журам;
- Аймаг, нийслэлийн тээвэр зохицуулалтын албадын үлгэрчилсэн дүрэм;
- Авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг;
- MNS 5831-2007 Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага;
- MNS 4978-2000 Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5645-2006 Барилгын ширхэгийн ба нурмаг ачаа тээвэрлэлт. Ангилал, тээвэрлэлтийн нөхцөл, шаардлага;

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

- MNS 4599-2003 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд;
- MNS 4598-2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага;
- MNS 4601-2011 Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын систем, тодорхойлолт;
- MNS 5344-2011 Ахуйн хог хаягдал тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5345-2003 Овор ихтэй, урт, хүнд ачааны тээвэрлэлт. Ангилал, ерөнхий шаардлага;
- MNS 5346-2003 Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ;
- MNS 4597-2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4759-2014 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5343-2003 Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх. Ангилал. Ерөнхий шаардлага;
- MNS 5044-2003 Оношлогооны төв – Ангилал, ерөнхий шаардлаг;
- MNS 5014-2003 Дизель хөдөлгүүртэй автомашин – Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга;
- MNS 5013-2003 Бензин хөдөлгүүртэй автомашин – Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.

4.3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлагууд

Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий (БОНБЕҮ) болон Нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ) нь Монгол улсын хуулиар шаарддаг үнэлгээнүүд юм. Эдгээр үнэлгээ нь: (1) төлөвлөж буй төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байгаль орчны нөхцөл ямар байсан, (2) санал болгож буй төсөл ямар нөлөөтэй байх, (3) нөлөөллүүдийг бууруулахад төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээнүүд гэсэн гурван үндсэн бүрдэл хэсэгтэй байдаг. Монгол улсын хууль тогтоомжоор эдгээр үнэлгээ нь төслийн зөвшөөрлийн нөхцлийг төлөөлөх бөгөөд үнэлгээнд орсон шаардлага заалтууд нь заавал биелүүлэх үүрэг болдог ба энэ нь барууны орнуудад зөвшөөрлийн нөхцлүүдийг даган мөрдөхтэй төстэй юм.

4.4 Баримталбал зохих олон улсын стандарт, удирдамжууд

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн асуудалд баримталбал зохих олон улсын стандарт, удирдамжуудаас дурдвал:

- Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт, 2012 он;
- ОУСК-ийн удирдамж: Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт;
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас баталсан (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлагууд, 2014 он (ГШ);
- Олборлолтын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулан ОУСК-иас баталсан Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн удирдамж (2007 оны XII сар) – Тэсэрч дэлбэрэх бодис зэрэг аюултай материал тээвэрлэх шаардлагууд мөн хамаарна.
- ОУСК-иас баталсан Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн ерөнхий удирдамжууд.

Гацуурtын төсөл ЕСБХБ-наас санхүүжилт авахыг зорьж байгаа бөгөөд тус банкнаас тавьдаг Гүйцэтгэлийн шаардлагуудыг биелүүлэхийг эрмэлзэж ажиллана. Тиймээс ЕСБХБ-наас тавьсан замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдлын менежментийн үндсэн шаардлагуудыг дор товч дурдав. Үүнд:

- Зээлдэгч төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид ажиллагсад болон нөлөөлөлд өртөх магадлалтай орон нутгийнханд учирч болзошгүй замын хөдөлгөөн, замын аюулгүй байдлын эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлгээ хийж, хяналт тавихын зэрэгцээ тохиромжтой тохиолдолд тэдгээр эрсдэлийг авч үзэж, шийдвэрлэхэд чиглэсэн зохих арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулна. Нийтийн хэрэглээний зам дээр хөдөлгөөнт тоног төхөөрөмж ажиллуулдаг, түүнчлэн бусад хэлбэрийн дэд бүтцийн төхөөрөмж ашигладаг төслүүдийн хувьд зээлдэгч тухайн тоног төхөөрөмжийн ашиглалтаас үүдэн осол зөрчил гарах, иргэдэд бэртэл, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэхийг эрмэлзэж ажиллана.
- Зээлдэгч замын хөдөлгөөн, замын аюулгүй байдлын менежментийн талаарх Европын Холбооны холбогдох стандартуудыг харгалзан үзэж, замын аюулгүй ажиллагааг хангах арга

хэмжээнүүдийг тодорхойлж, тэдгээрээс техник, эдийн засгийн хувьд үндэслэлтэй бөгөөд зардалд хэмнэлттэй бүрдэл хэсгүүдийг нь төслийн зураг төсөлд нэгтгэн тусгана. Энэ нь эрсдэлд өртөж болзошгүй орон нутгийнханд замын аюулгүй ажиллагааны асуудлаас үүдэн үзүүлэх магадлалтай нөлөөллийг бууруулах зорилготой юм. Зохистой тохиолдолд, зээлдэгч аюулгүй ажиллагааны талаарх сөрөг чиг хандлага, асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх зорилгоор төслийн үе шат бүрт замын аюулгүй ажиллагааны аудит хийж, осол зөрчил, ослын тайлангуудад тогтмол хяналт тавьж ажиллана. Өөрийн эзэмшил, өмчлөлийн эсвэл түрээсийн тээврийн хэрэгслүүд эсвэл автобаазтай зээлдэгчдийн хувьд, жолоочийн түүнчлэн тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны зохих сургалтад ажилчдаа хамруулна. Төслийн бүх тээврийн хэрэгсэлд тогтмол засвар үйлчилгээ, арчлалт хийж байх явдлыг зээлдэгч хангана.

4.5 Баримталбал зохих Сентеррагийн стандартууд

Менежментийн төлөвлөгөөг Сентерра компанийн Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль хамгаалал ба тогвортой хөгжлийн бодлогын хүрээнд боловсруулав.

5. НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ

Энэ хэсэгт тодорхойлсон хяналтын арга хэмжээ, замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн хөтөлбөрийг Гацуурт төслийн Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээнд (I Хавсралтыг үзнэ үү) тодорхойлсон эрсдлүүдэд зориулан боловсруулсан болно. Гацууртын барилга угсралт, Ашиглалт, Хаалтын үе шатуудад ашиглах хяналтын арга хэмжээг Хүснэгт 2-д оруулав. Газар, бэлчээр болон түүнд түшиглэдэг амьжиргаанд хамааралтай нөлөөллийн менежментийн хяналтыг Нийгмийн Нөлөөллийн Менежментийн төлөвлөгөөнд тодорхойлов. Эдгээр арга хэмжээг хураангуйлан дурдвал:

- Сумын хөгжлийн сангаар дамжуулан санхүүжүүлсэн үйл ажиллагаануудын хүрээнд бэлчээр сайжруулах багц арга хэмжээг дараах зорилгоор тусгах. Үүнд:
  - Мал амьтны эрүүл мэндийн асуудал болон мал сүргийн менежментийг боловсронгуй болгох, улмаар амьжиргаагаа сайжруулахад нь малчдад дэмжлэг үзүүлэх;
  - Орлогын эх үүсвэр бий болгох, эх үүсвэрээ олон хувилбараар төрөлжүүлэх зорилго бүхий малчдын хамтын ажиллагааны санаачилгуудыг дэмжих;
  - Бэлчээр, мал аж ахуйн салбарын болон нүүдлийн соёлыг хадгалан үлдээх.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

Хүснэгт 2 Менежментийн үндсэн хяналтууд

Лавлах дугаар	Хамрах сэдэв/асуудал	Төслийн холбогдох үе шат	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Гүйцэтгэлийн шалгуур
ЗХАБМТ/001	ЗХАБМТ-г сайжруулах замын хөдөлгөөний мэдээлэл	Барилга/ Ашиглалт	Одоогийн замын хөдөлгөөний байдлыг илүү дэлгэрэнгүй тодорхойлох үүднээс Төслийн талбайд замын хөдөлгөөний нарийвчилсан судалгаа хийх. Цуглуулсан өгөгдөл, мэдээг ЗХАБМТ-г нарийвчлан боловсруулахад ашиглах. Энэ нь замын хөдөлгөөний анхан шатны судалгаанд түшиглэнэ.	Олон нийтийн харилцааны хэлтэс	Замын хөдөлгөөний судалгааны тайлан ЗХАБМТ-ний шинэчилсэн хувилбар
ЗХАБМТ/002	Бүхэлдээ	Барилга / Ашиглалт	Шууд болон шууд бус хамааралтай ажиллагсдын (өөрөөр хэлбэл, Төслийн болон гэрээт гүйцэтгэгчид) баримталбал зохих, Төслийн барилга угсралт, олборлолтын үе шатууд дахь тээврийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмжийн шилжилт хөдөлгөөний менежментийг энэ төлөвлөгөөг сайжруулан хэрэгжүүлэх. Үүнд, дор хаяж дараах асуудлуудыг хамруулсан байна. Үүнд: • Машин, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний хуваарь гаргах; • Зам тээврийн осол; • Зам тээврийн ослын улмаас хүний амь эрсдэх; • Мал амьтан мөргүүлж гэмтэх, үхэж үрэгдэх; • Замын инженерийн шийдэл; • Талуудыг татан оролцуулах арга хэмжээнүүд. Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд Төслийн жолооч нар болон ачааны машинуудад тавих дотоод хяналтыг боловсруулж, хэрэгжүүлэх. Үүнд:	Барилга хариуцсан менежер Үйл ажиллагаа хариуцсан менежер Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Гэрээ, худалдан авалтын хэлтэс Уурхай, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон тогтвортой байдлын асуудал хариуцсан менежерүүд	Аудит, үзлэгийн бүртгэл, тэмдэглэл Дотоод хяналтын арга хэмжээг мөрдүүлсэн байдал Биелэлтийн талаарх бүртгэл, тэмдэглэл

			• Хурдны хяналт/ тээврийн хэрэгслийн төрлөөр хязгаарлалт/ зорчих цаг/ нөхцөлд байдалд тохируулж хөдөлгөөнд оролцох; • Согтууруулах ундаа, эм, мансууруулах бодису хэрэглээний талаарх бодлого; • Аюулгүй ажиллагааны журам; • БГК-ийн стандарт шаардлагын дагуу согтууруулах ундаа, эм, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох цусны шинжилгээнд жолооч нарыг хамруулах; • Жолоочийн таних тэмдэг, тээврийн хэрэгслийн дугаар нь замаар зорчигч бусад хүмүүст танихад хялбар, тодорхой байх; • Тээврийн хэрэгслэл жолоодох зөрчил гаргасан, хурд хэтрүүлсэн тохиолдолд арга хэмжээ авдаг байх; • Ээлж эхлэх бүрийн өмнө тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны үзлэг бүрэн хийх; • Хүдэр тээвэрлэх бүх ачааны машинуудын аюулгүй ажиллагааны үзлэгийг БГК жил бүр хийх; • Тээврийн хэрэгслээ зогсоолд тавихад мөрдөх техникийн шаардлага, үзүүлэлтүүд; • Эвдрэл, гэмтэл ба сэргээн засварлахад тавигдах техникийн шаардлага, үзүүлэлтүүд; • Тээврийн хэрэгсэлд үзлэг, засвар үйлчилгээ, арчлалт хийсэн тухай протоколууд; • Харилцаа холбоонд баримтлах протоколууд.		
ЗХАБМТ/003	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам	Барилга, ашиглалтын үе шат	ЗХАБМТ-ний хэрэгжилтийг хянах, мониторинг хийх, зохицуулах зорилгоор олон хэлтэстэй дотоод хороо байгуулах. Дотоод хороо нь ЗХАБМТ-г	Үйл ажиллагаа хариуцсан менежер	Хурал, уулзалтын

	тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул		тогтмол (барилга угсралтын ажлын үед болон олборлолтын үйл ажиллагааны эхэн үед жилд хоёр удаа) хянах бөгөөд эрх бүхий төрийн байгууллагууд, орон нутгийн иргэдийн төлөөллийг энэ үйл ажиллагаанд оролцуулахаар урина.	Хүний нөөцийн менежер Олон нийтийн харилцааны хэлтэс Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал	протокол, тэмдэглэл
ЗХАБМТ/004	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Нийтийн хэрэглээний тээврийн замыг Төсөл үргэлжлэх хугацааны туршид арчлах.	Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал	Засвар үйлчилгээ, арчлалтын талаарх бүртгэл, тэмдэглэл
ЗХАБМТ/005	Зам тээврийн осол гарах эрсдэлийг доод түвшинд хүргэх зорилго бүхий инженерийн шийдэл	Барилга, ашиглалт, Хаалтын үе шат	Уурхайн хаалтын төлөвлөлтийн хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагуудтай тохиролцох аваас Төсөл хэрэгжиж дуусмагц нийтийн замыг зөвхөн нийтийн хэрэглээнд ашиглах зориулалтаар шинэчлэн сайжруулах, өөрчлөхөд зарцуулах хөрөнгө мөнгийг тусад нь байршуулж хадгалах.	Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал	Санхүүгийн бүртгэл, тайлан Туслах авто замуудыг өөрчлөн сэргээх төлөвлөгөө Хурал, уулзалтын протокол, тэмдэглэл
ЗХАБМТ006	Төслийн машин, тээврийн хэрэгслүүд ба олон нийтийн дунд зам тээврийн осол гарах эрсдэлийг доод түвшинд хүргэх зорилго бүхий замын инженерийн шийдлүүд	Барилга, ашиглалтын үе шат	Орон нутгийн тээврийн хэрэгслүүд төслийн тээврийн хэрэгслүүдтэй тулгарах эрсдэлгүйгээр зөрж өнгөрөх боломжийг бүрдүүлж, ачааны машинууд замын хажууд түр зогсох тэмдэг, тэмдэглэгээтэй, аюулгүй газруудыг бий болгох. • Хоёр том машин аюулгүй зөрж өнгөрөх боломж бүрдүүлэх үүднээс зарим тодорхой газруудад замыг өргөсгөх. • Үзэгдэх орчин хязгаарлагдмал эргэх уулзвар, өгсүүр газрын орой дээгүүр явахын өмнөх сэрэмжлүүлэг өгөх, эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн инженерийн шийдэл.	Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал	Замын тэмдгүүд байршуулах, аюулгүй зөрж өнгөрөх газруудыг бий болгох буюу тогтоох Засвар үйлчилгээ, арчлалтын талаарх бүртгэл, тэмдэглэл

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

ЗХАБМТ007	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Орон нутгийнхны хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөөнд тоймлон тусгасанчлан жолооны сургалтад хамруулах, үнэлгээ хийх ажлуудыг товч дурдвал: • Тухайн үед ажиллаж буй жолооч нарын жолооны үнэмлэх хүчинтэй байх; • Компанид гүйцэтгэх ажил үүрэгт нь дадлагажуулах; • Ахисан шатны жолооны сургалт (албан тушаал, ажил үүргийнх нь шаардлагад нийцүүлэн); • Ил уурхай руу орох, нэвтрэх зөвшөөрөл.	Сургалтын менежер	Сургалтын талаарх бүртгэл, тэмдэглэл
ЗХАБМТ008	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул Тоосны менежмент	Ашиглалтын үе шат	Ачааны машинаас сул чулуу унаж, бусдын тээврийн хэрэгсийг гэмтээх, түүнчлэн тоосны бохирдол үүсэхээс сэргийлэхийн тулд ачааг бүтээх зэргээр ачааны машинд хяналт тавих (ачааг аюулгүй, найдвартай болгоогүй тохиолдол гаргахгүй байх).	Үйл ажиллагаа хариуцсан менежер Уурхай, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон тогтвортой байдлын асуудал хариуцсан менежерүүд	Үзлэгүүдийн бүртгэл, тэмдэглэл
ЗХАБМТ009	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд эрх бүхий байгууллагуудтай боломжит хүрээнд харилцаа холбоотой ажиллахаар зохих хүчин чармайлт гаргах: • Хурдны хязгаар тогтоож, биелэлтийг хангуулах • Аюулгүй байдлыг хангах үүднээс машин, тээврийн хэрэгслүүдэд гэнэтийн шалгалт хийх • Жолооч нарын цусны шинжилгээгээр илрэх согтууруулах ундааны хэмжээнд хязгаар тогтоож, биелэлтийг хангуулах • Машин, тээврийн хэрэгсэл осолд орох, осол зөрчил гарах үед авах арга хэмжээний аргачлал боловсруулж, сургалт	Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Олон нийтийн харилцааны хэлтэс	Татан оролцуулсан тухай бүртгэл, тэмдэглэл (ОТТОТ-нд бүртгэсэн) Онцгой тохиолдол, ослын үед авах хариу арга хэмжээний талаарх хамтарсан сургалт (Онцгой тохиолдол, ослын үед авах

			зохион байгуулах, хэн ямар үүрэг, хариуцлага хүлээхийг тодорхой тусгах		арга хэмжээний төлөвлөгөөг үзнэ үү)
ЗХАБМТ010	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд нутгийнхны оролцоог хангаж ажиллах. Үүнд: • Хурдны хязгаар, суудлын бүс болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, арчлалтын асуудлуудыг онцлон тэмдэглэсэн замын аюулгүй ажиллагааны талаарх кампанит ажиллагааг түншлэгч байгууллагуудтай хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх; кампанит ажиллагааны тодорхой хэсгийг ахмад настай жолооч, хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхэнд мөн чиглүүлэх нь зүйтэй.	Олон нийтийн харилцааны хэлтэс	Хамтын ажиллагааны талаарх бүртгэл, тэмдэглэл Кампанит ажиллагааны талаарх бүртгэл, тэмдэглэл Татан оролцуулсан тухай бүртгэл, тэмдэглэл (ОТТОТ-нд бүртгэсэн)
ЗХАБМТ011	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд нутгийнхны оролцоог хангаж ажиллах. Үүнд: • Тээвэрлэлтийн хугацаа, давтамж болон зам ашиглагчдад үүсч болзошгүй эрсдэлийн талаар олон нийтэд урьдчилан мэдэгдэх. Ийнхүү мэдэгдэхдээ олон нийттэй хурал, уулзалт хийхээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс телевизийг голчлон сонгох. Мөн сонин сэтгүүл ашиглахын зэрэгцээ Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу олон нийтийн харилцаа эрхэлсэн албан тушаалтнуудыг дайчлан оролцуулах; тээвэрлэлтийн ажиллагаа эхлэхээс өмнө мэдээллийг хангах.	Олон нийтийн харилцааны хэлтэс Үйл ажиллагаа хариуцсан менежер	Мэдэгдэж, татан оролцуулсан тухай бүртгэл, тэмдэглэл (ОТТОТ-нд бүртгэсэн)
ЗХАБМТ012	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам	Барилга, ашиглалтын үе шат	Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд нутгийнхны оролцоог хангаж ажиллах. Үүнд:	Олон нийтийн харилцааны хэлтэс	Мэдэгдэж, татан оролцуулсан

	тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул		• Тав тух алдагдуулсан асуудлаар эсвэл аль нэг жолоочид холбогдуулан гомдол гаргахад баримтлах “Гомдол барагдуулах аргачлал, журам”-ын талаар мэдэгдэх		тухай бүртгэл, тэмдэглэл (ОТТОТ-нд бүртгэсэн)
ЗХАБМТ013	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Осол зөрчил гарах магадлалыг багасгахын тулд нутгийнхны оролцоог хангаж ажиллах. Үүнд: • Өөр бусад машин, хүн, мал осолд орж гэмтэх зэрэг онцгой тохиолдол, ослын үед үзүүлэх үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх (мэдээллийг замын хажуу хэсгүүдэд байршуулах түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх зэргээр). • Нийтийн хэрэглээний зам дээр мал амьтантай мөргөлдөх эрсдэлийг бууруулах аргачлал нь хүмүүс болон бусад машин, тээврийн хэрэгслүүдийн тухайд дээр дурдсантай ижил байна гэдгийг энд тэмдэглэвэл зохино.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан менежер Олон нийтийн харилцааны хэлтэс	Мэдэгдэж татан оролцуулсан тухай бүртгэл, тэмдэглэл (ОТТОТ-нд бүртгэсэн)
ЗХАБМТ014	Төслийн тээврийн хэрэгслүүд холбогдсон зам тээврийн осол, хүний амь нас эрсдэх аюул	Барилга, ашиглалтын үе шат	Онцгой тохиолдол, ослын үед бэлтгэлтэй байж үүргээ гүйцэтгэхэд нь дадлага олгох сургуулилалтыг Онцгой тохиолдол, ослын менежментийн багийнханд хийх	Үйл ажиллагаа хариуцсан менежер Уурхай, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон тогтвортой байдлын асуудал хариуцсан менежерүүд Сургалтын менежер	

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11

6 ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Менежментийн төлөвлөгөөг хянан нягталж, шинэчлэх

Хэлтэс хоорондын дотоод хороо нь ЗХАБМТ-ний хэрэгжилтийг хянаж, мониторинг, зохицуулалт хийнэ. Дотоод хороо нь ЗХАБМТ-г барилгын ажлын үед болон ашиглалтын эхэн үед жилд хоёр удаа, түүнээс хойших хугацаанд доод тал нь жилд нэг удаа тогтмол хянаж шалгах бөгөөд уг процесст оролцох эрх бүхий байгууллага болон нутгийнхны төлөөлөгчдөөс бүрдэх шинжээчдийг урина. ЗХАБМТ-нд өөрчлөлт оруулах хэрэгцээ гарвал, оролцогч талуудад мэдээлнэ. Үйл ажиллагааны журамд томоохон өөрчлөлт оруулах шаардлага үүсвэл (Гацууртын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн системд (ЭМААБОМС) заасан Өөрчлөлтийн менежментийн журмын дагуу тодорхойлсончлон), Менежментийн төлөвлөгөөг “тухайн шаардлага үүссэн тохиолдолд” шинэчилж болно.

Менежментийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрт шинэ хувилбартай нь танилцах боломжийг холбогдох бүхий л ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчдэд олгож, таниулан сурталчилна. ЗХАБМТ-г хэвлэн нийтэлж болохын зэрэгцээ нэмэлт өөрчлөлт орсон хувилбарыг нь орон нутгийнхантай хурал, уулзалт зохион байгуулах, Мандал, Баянгол сумд, Түнхэл тосгоны засаг дарга нар болон холбогдох бусад талуудад илгээж сурталчлан таниулна. Хэрэв ЗХАБМТ-тэй танилцахыг хүсвэл хаанаас авч үзэж болох тухай мэдээлнэ. БГК-ийн Олон нийтийн мэдээллийн төвүүд дээр хэдийд ч очиж ЗХАБМТ-тэй танилцах боломжтой байлгах бөгөөд тус баримт бичигт сүүлийн үед оруулсан аливаа өөрчлөлтийн талаар тодруулга өгнө.

7 ХЯНАЛТ

7.1 Хяналт хийхэд тавигдах шаардлагуудын тойм

Төслийн стандартуудын шаардлагуудын биелэлтэд үнэлгээ хийх үүднээс уурхайн барилга, ашиглалтын үе шатуудад хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээнүүдийг энэ бүлэгт тодорхойлов (‘Төслийн стандартууд’ гарчигтай IV бүлгийг үзнэ үү).

Төслийн стандартуудын хэрэгжилтийн зөрчил хяналтаар тогтоогдсон тохиолдолд түүний мөрөөр шалгаж, зохих хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.2 Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд

Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд болон эрсдлийг бууруулахэд арга хэмжээний үр дүнг үнэлэх хяналтын аргуудыг энэ хэсэгт хураангуйлан оруулав.

Хүснэгт 3 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт ба хяналтын арга хэмжээ – Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент

Лавлах дугаар	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилт
ЗХАБМТ-ГШҮ 01	Уурхайн замын хөдөлгөөнтэй холбоотойгоор ноцтой гэмтэл, бэртэл учрах, хүний амь эрсдэхэд хүргэсэн осол зөрчлийн тоо	Тэг
ЗХАБМТ-ГШҮ 02	Заавал хамруулах жолооны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт	90%
ЗХАБМТ-ГШҮ 03	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн талаарх орон нутгийнхны гомдлын мөрөөр хариу арга хэмжээ авах	Аливаа гомдолд 14 өдрийн дотор хариу өгнө
ЗХАБМТ-ГШҮ 04	Уурхайн машин, тээврийн хэрэгслүүд холбогдсон замын хөдөлгөөний осол зөрчлийг шалгаж, учир	Замын хөдөлгөөний үеэр гарсан осол зөрчил

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
ХЭВЛЭСЭН ӨДӨР: 2016-05-11

Лавлах дугаар	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилт
	шалтгааныг тодруулан, тогтоож хариу арга хэмжээг төлөвлөх	бүрийг 30 өдөрт багтаан бүрэн гүйцэд шалгана
ЗХАБМТ-ГШҮ 05	Жолооч нарт тавих өдөр тутмын хяналт нь согтууруулах ундааны хэрэглээний талаар БГК-ийн баримталдаг бодлогод нийцэж байгааг баталгаажуулсан байх	100%

7.3 Хяналтын үндсэн үйл ажиллагаа

Хяналтын үйл ажиллагаа нь Төслийн үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, амьжиргаа, бэлчээр, газар, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлж буй эсэхэд үнэлгээ хийх замын хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд голлон төвлөрнө. Төслийн стандартуудын хэрэгжилтийн зөрчил тогтоогдвол осол зөрчил хэмээн бүртгэж шалгахын зэрэгцээ авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлно (ЭМААБОМС-ийн баримт бичгээс дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү). Хяналтын үндсэн арга хэмжээнүүдийг дор тусгав.

Хүснэгт 4 Хяналтын үндсэн арга хэмжээ

Лавлах дугаар	Хамрах сэдэв/асуудал	Аргачлал	Давтамж	Байршил
ЗХАБМХ 001	Замын хөдөлгөөний өгөгдөл, мэдээ	• Замын хөдөлгөөний судалгаа	Барилгын ажил эхлэхийн өмнө; түүнээс хойшхи хугацаанд жил бүр	Төслийн талбай (Гацууртын тээврийн замд голлон төвлөрнө)
ЗХАБМХ 002	Замын аюулгүй байдал	• Замын нөхцөлд хяналт тавих	Жилд хоёр удаа	Төслийн талбай (Гацууртын тээврийн замд голлон төвлөрнө)
ЗХАБМХ 003	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд	• Ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгчид согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг тусгай багажаар үлээлгэж шалгах	Өдөр бүр	Ажлын талбай
ЗХАБМХ 004	Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа	• Ээлж эхлэх бүрийн өмнө тээврийн хэрэгслийн аюулгүй байдалд бүрэн үзлэг, шалгалт хийх	Өдөр бүр	Ажлын талбай
ЗХАБМХ 005	Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа	• БГК-ийн зүгээс хүдрийн тээвэрт ашиглагдах бүх ачааны машинд жил тутмын тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны хяналтын арга хэмжээ авах	Жил бүр	Ажлын талбай

8 СУРГАЛТ

Гацууртын бүх ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчдийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн чиглэлээр Гацуурт дахь ажил үүрэгт тохирсон зааварчилгаа сургалтад хамруулна. Гацууртын тээврийн замаар жолоо барих ажиллагсад болон гүйцэтгэгчид, ялангуяа ачааны машины жолооч нарт голлон анхаарч, ахисан шатны нэмэлт сургалт өгнө. Бүхий л ажиллагсдыг хүчинтэй жолооны үнэмлэхтэй байхыг шаардана. Түүнчлэн, ил уурхайн талбайд нэвтрэх жолооч нар

зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Үүнээс гадна, тодорхой зарим албан тушаал, ажил үүрэг эрхлэгчдийг ахисан шатны жолооны сургалтад хамруулж болно.

9 АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

9.1 Дотоод аудит

Үйл ажиллагаа явагдаж буй газруудад ахлагч болон жолооч нар тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, жолоочийг шалгах зэргээр өргөн хүрээтэй үйл ажиллагаануудыг хамруулан өдөр бүр шалгалт хийнэ (IV хүснэгтийг үзнэ үү).

Эдгээр үзлэгийн үед ямар нэг осол зөрчил илэрвэл ЭМААБОМС-ийн осол зөрчил менежментийн системд тайлагнана.

БГК-ийн ЭМААБОМС-ийн дагуу жил тутмын дотоод аудитын хөтөлбөрөөр дамжуулан биелэлтэд хяналт тавина. ЭМААБОМС-ийн менежментийн тогтолцооны шаардлагууд ерөнхийдөө хангагдаж буй эсэхэд үнэлгээ хийх үүднээс уг хяналтыг хэрэгжүүлнэ.

Эдгээр үзлэгээр илэрсэн бүхий л осол зөрчлийг Гацууртын ЭМААБОМС-ийн шаардлагуудын дагуу мэдээлж тайлагнана.

9.2 Хөндлөнгийн аудит

Сентеррагийн аудитын хөтөлбөрийн хүрээнд түүнчлэн Төслийн зээлдүүлэгчдийн зүгээс энэхүү төлөвлөгөөний биелэлтэд тогтмол үнэлгээ хийнэ.

Гацууртын энэхүү ЭМААБОМС болон ЗХАБМТ-ний хэрэгжилт хангагдаж буй эсэхэд аудит хийх хөндлөнгийн аудиторыг урьж ажиллуулна.

9.3 Бүртгэл, тэмдэглэл хөтлөх

Аудитын шалгалт, үзлэг, осол зөрчилийн бүртгэл, тэмдэглэл хөтлөлтийг Гацууртын журмуудын дагуу хийнэ.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
ХЭВЛЭСЭН ӨДӨР: 2016-05-11

Хавсралт 1: Олон нийтийн замын хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийн талаарх хураангуй

Төсөлтэй холбоотой замын хөдөлгөөний гол эрсдэлүүдийн талаар ерөнхий мэдээлэл өгөх үүднээс автотээврийн замын бүтээн байгуулалтын явцыг товч танилцуулья.

- Мандал сумын удирдлагуудтай гэрээ байгуулсны дагуу нийтийн хэрэглээний замыг 2010 онд барьсан.
- 2015 онтой харьцуулахад тэр үеийн тээврийн хэрэгслийн тоо цөөн, мөн тухайн үеийн замны чанараар шалтгаалан хурд хэтрүүлэх асуудал бага байсан зэргээс замын ослоор нас барах, хурд хэтрүүлэх зэрэг асуудал ноцтой түвшинд тооцогдохоргүй байсан.
- Эрсдэл бууруулах шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд оролцогч талуудын санал, дүгнэлтэд үндэслэн авто замын зураг төслийн эцсийн хувилбартаа тариаланчдын талбай, малчдын өвөлжөө, хүүхдийн зуслангийн газруудыг тойруулахаар тусгаж чадсан. Үүнээс гадна, тухайн үед хэдийнэ гаргачихсан байсан маршрутыг аль болох дагаж зам гаргасны зэрэгцээ нөлөөлөлд өртөж болзошгүй субъектуудыг (рашаан, булаг, ховор ан амьтдын амьдрах орчин, мал, амьтдын нүүдэллэн өнгөрөх, археологийн болон соёлын чухал ач холбогдол бүхий газрууд, өвөлжөө, зуслан, байнгын сууц зэргийг хамруулан) дайралгүй тойрч гарч чадсан билээ.
- Холбогдох төрийн байгууллагуудаас (Монгол улсын Зам тээвэр, Аялал жуулчлалын яам) зам барих зөвшөөрөл олгоход тавьсан гол нөхцөл нь уурхайн тээврийн замыг нийтийн хэрэглээний (зөвхөн БГК тээврийн замын зориулалтаар дангаараа ашиглах бус) болгон барих байв.

Бэлчээр ашиглалтад үзүүлэх авто замын нөлөөлөл

Төслийн зүгээс бэлчээрт үзүүлэх нөлөөлөл нь нийтийн хэрэглээний зам ашиглалтаас үүдэн бэлчээр ашиглагчдын тав тухыг алдагдуулах асуудал, ялангуяа Төслийн машин, тээврийн хэрэгслүүдээс гарах тоос, дуу чимээ, доргио, чичиргээ нь тэдгээр зам дагуух бэлчээр, тариалангийн газрын чанар болоод ашиглах боломж, хүртээмжид нөлөөлөх явдал юм. Зам дагуух газар ашиглагчид Төслийн замын хөдөлгөөний улмаас тоосжилт нэмэгдэх, бэлчээр болон тариалангийн талбайд тоосжилт үүсэх зэрэг нөлөөлөлд өртөж болзошгүй. Нийтийн хэрэглээний замыг одоогоор хучаагүй байгаа бөгөөд Сентеррагийн зүгээс шаардлагатай үед тодорхой давтамжтайгаар хусаж тэгшилдэг. Одоохондоо уг замд тоос дарагч хэрэглээгүй байгаа. Замын хөдөлгөөний талаарх анхан шатны судалгаагаар (2015 оны) Бороо, Гацуурт, Зүүнхараа хоорондын нийтийн хэрэглээний замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тоо, төрлийг судалсан. Бэлчээр ашиглагчид, тариаланчдад нөлөөлөл үзүүлэх магадлал өндөртэй хэсэг нь Бороо, Зүүнхараагийн хоорондын зам байна. Зүүнхараагийн уулзвар гарцаас Гацуурт хүртэлх замд бэлчээр, тариалангийн талбай бага, харин ой мод ихтэй. Энэ замаар ихэнхдээ Улаанбаатарын замаас (баруун зүгт байх) Зүүнхараа чиглэсэн суудлын тэрэгнүүд өдрийн цагаар орчдог нь судалгаанаас харагдсан. Суурь судалгаанаас үзвэл, уг зам чанар сайтай тул суудлын тэрэгнүүд хурдтай давхих нь элбэг, тоос их босгодог байна. Анхан шатны судалгаанаас харахад, өдөрт янз бүрийн 70 орчим машин энэ хэсгээр зорчих аж.

Ачааны машинууд тухайн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслүүдээс илүү том овортой, дуу чимээ ихтэй хүнд даацынх тул Гацуурт–Бороогийн нийтийн хэрэглээний замын хажууд байрлах айл өрхүүдэд үзүүлэх тоос, дуу чимээ, доргио, донсолгооны нөлөөлөл нь мөн илүү өндөр. Суурь судалгааны үед замын ойролцоо гэр сууцтай (хагас нүүдлийн) 18 айл өрх (нөлөөлөлд өртөж болзошгүй) аж төрж байв. Өдрийн ямар үед тээвэр хийснээс хамаарч тэдгээр субъектын дуу чимээ, доргио, донсолгоонд өртөх нөлөөлөл өөр өөр байх боломжтой. Шөнийн цагаар орчны чимээ багатай үед нөлөөлөл илүү өндөр байна гэж үзэж буй. Орчны нөхцөл илүү хуурай, салхи ихтэй хаврын улиралд тоосжилт үүсэх нь хамгийн их байна.

Иргэдийн амьжиргаанд үзүүлэх авто замын нөлөөлөл

Төслийн машин, тээврийн хэрэгслүүд, ялангуяа ачааны машинууд уурхайн ашиглалтын үе шатанд нийтийн хэрэглээний замаар тээвэр хийх үед мал амьтантай мөргөлдөх тохиолдол нэмэгдэж болзошгүй. Уурхайн машнууд орон нутгийн бусад машинуудаас бага хурдтайгаар хөдөлгөөнд оролцох боловч 30 орчим тонны ачаатай байх тул мал амьтантай мөргөлдөх эрсдэл үүсэхэд огцом хурдаа сааж зогсоход хүндрэлтэй. Суурь судалгааны мэдээгээр, 2014 оны байдлаар Мандал суманд мал амьтан машинд мөргүүлсэн тав хүрэхгүй осол бүртгэгджээ (Баянгол суманд осол бүртгэгдээгүй). Энэ нь сумын хэмжээний хувьд бага тоо мэт боловч гарсан ослыг бүртгүүлэлгүй, малчид болон тээврийн хэрэгслийн эзэд хоорондоо тохиролцсон тохиолдол байвал энэ тоо тоо бага байх талтай.

Хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөлөөллийг багасгах нь нэн тэргүүний асуудал юм. Тиймээс, энэ асуудалд хамаарах хариу арга хэмжээнүүд нь мал амьтдад түүнчлэн малчдын амьжиргаанд үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах явдлыг хангана.

Замын хөдөлгөөний үеэр осол зөрчил гарах

Төслийн шууд нөлөөгөөр тээврийн хэрэгслийн ялангуяа хүнд даацын ачааны машины замын хөдөлгөөн нэмэгдэнэ. Тухайлбал төслийн талбайд барилгын материал авчрах, ажлын талбай хооронд мөн дотроо ажиллагсдыг болон ачаа бараа тээвэрлэх ажиллагаа орохоос гадна Гацуурт, Бороогийн уурхайн талбай хоорондын нийтийн хэрэглээний замаар зорчих ачааны машинууд хамгийн их нөлөө үзүүлэх юм. Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ийнхүү нэмэгдэх нь орон нутгийн иргэд осолд өртөх, амь насаа алдах хүртэл эрсдэлийг үүсгэна. Ослын үед арга хэмжээ авах орон нутгийн бололцоо хязгаарлагдмал байна (2015 онд хийсэн Нийгэм, эдийн засгийн суурь судалгаанаас үзэхэд, ноцтой осол гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах нөөц бололцоо, боломж хязгаарлагдмал, ялангуяа эмнэлгийн мэргэшсэн боловсон хүчин, хангалттай тоноглосон эмнэлэг, үйлчилгээний байгууламж дутмаг байдалтай байна). Сентерра онцгой тохиолдол, ослын үед хариу арга хэмжээ авах чиг үүрэг бүхий өөрийнхөө багийг энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин болон зориулалтын машин унаа, тоног төхөөрөмжөөр ханган бүрдүүлнэ. Осол гарсан үед орон нутгийн эрх бүхий байгууллагууд түргэн шуурхай арга хэмжээ авах боломжоор тааруу учир тухайн ослоос үүдэх үр дагавар ноцтой хэмжээнд хүрэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Төслийн машин, тээврийн хэрэгслийн улмаас гэмтэл, бэртэл учрах, хүний амь эрсдэх нь орон нутгийн шинжтэй, урт хугацаат, шууд, сөрөг нөлөөлөл юм (өөрөөр хэлбэл Төслийн туршид үргэлжлэх нөлөөлөл. Гэхдээ ачааны машинуудыг ашиглах ашиглалтын үе шатанд эрсдэл хамгийн өндөр байх юм).

2015 онд замын хөдөлгөөний сууоь судалгаа хийсэн. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт буюу Баянгол суманд замын хөдөлгөөний ослын гол шалтгаанууд нь урсгал сөрж явах, хурд хэтрүүлэх явдал байсан бол Мандал сумын хувьд согтуугаар жолоо барих, хурд хэтрүүлэх, тоормослож чадахгүй байх нь зам тээврийн ослын гол шалтгаан болдог аж. Баянголд гарсан бүх гэмт хэргийн бараг гуравны нэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой байгаа нь ОХУ - Улаанбаатар хоорондын засмал замд ойрхон оршдогтой холбоотой байх магадлалтай.

Биет бус соёлын өв болон олон нийтийн аюулгүй байдал

Гацууртын талбайн Төслийн дэд бүтцийг шүтлэг тахилгатай овоонууд зэрэг нөлөөлөлд өртөж болзошгүй чухал ач холбогдолтой газруудад нөлөөлөхгүйгээр байгуулсан билээ. Эдийн засгийн боломжуудыг эрэлхийлж шилжин ирэгсдийн нөлөөгөөр нутгийн иргэд гадны соёлын нөлөө, тухайлбал, шашны зан үйл, нийгмийн өөр харилцаанд орох зэрэг гадны соёлын нөлөөнд автах нөхцлийг үүсгэж болзошгүй. Эдгээр нөлөө нь нутгийн иргэдийн хувьд заншиж тогтсон шүтлэг тахилгын ёсыг өөрөөр үйлдэх, Төслийн орчмын соёлын өвийн сурвалж болох түүх, аман ярианы өвд нөлөөлөх зэрэг байж болно. Соёлын өвтэй холбоотой гол асуудал нь сүүлийн жилүүдэд цугларах болсон уул овоо тахидаг, мөргөл үйлддэг хүмүүсийн болон Төслийн болон нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бөөгнөрөл юм. Уулын замд машин түр зогсоох зай талбай хомс учраас ашиглалтын үед ачааны машинууд явж өнгөрөхөд олон нийтэд эрсдэл үүсгэж болзошгүй юм.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.
PRINTED DATE: 2016-05-11